



ОЧИРЫН ЦЭНД

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга
1976-1978 он

Хуучин Засагт хан аймгийн Дэлгэрхааны хошуу, одоогийн Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын нутагт малчин ардын гэр бүлд 1918 онд төржээ. Тэрбээр 1941 онд Санхүүгийн техникум, 1947 онд ЗХУ-ын Эрхүү хотын Санхүү эдийн засгийн дээд сургууль, 1959-1990 онд Москва хотод аспирантурт суралцаж, эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан юм.

О.Цэнд 1947 оноос БНМАУ-ын Сангийн яаманд мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1953 оноос санхүүгийн техникумд багш, орлогч захирал, 1954 оноос Статистикийн төв газрын нэгдүгээр орлогч дарга, 1966- 1970 онд БНМАУ-ын Статистикийн төв газрын дарга, 1970-1976 онд БНМАУ-аас БНАВУ, БНАСАУ-

д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажилласан.

1976-1978 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1978-1981 онд БНМАУ-аас Куба улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ. МАХН-ын XV, XVI их хурлаас Намын төв хорооны орлогч гишүүн, XVII их хурлаас Намын төв хорооны гишүүнээр, БНМАУ-ын АИХ-ыг сонгох 6, 7, 8, 9 дэх удаагийн сонгуулиар АИХ-ын депутатаар сонгогдож байв.

Түүний ажлын үр бүтээлийг үнэлж “Алтан гадас” одон, ойн медалиудаар шагнажээ.

Нийслэл хотыг хөгжүүлэх гурав дахь удаагаа шинэчлэн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хотын тохижилт, үйлчилгээг сайжруулахад төр захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж, зохих хувь нэмэр оруулсан хүний нэг юм.